



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/13

Булган

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 /а/, 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 14/03 тогтоолоор батлагдсан аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн гэр бүл, хүний хөгжлийг дэмжих заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх, хүүхэд, залуучууд, иргэдийн сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалах, хөдөлмөр эрхлэх эрхийг хангах, тэдний нийгмийн хамгаалал, оролцоо, амьдрах нөхцлийг сайжруулах, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор 2020 оныг “Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарлахаар шийдвэрлэснийг үндэслэн аяны удирдамж, төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: - Ц.Бат-Өлзий /Аймгийн Засаг даргын орлогч/
Гишүүд:
- О.Наранжаргал /Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга/
- Д.Эрдэнэбилэг /АЗДТГ-ын ТЗУХ-ийн дарга/
- Б.Одхүү /АЗДТГ-ын ХЭЗХ-ийн дарга/
- Д.Батцогт /АЗДТГ-ын СТСХ-ийн дарга/
- Д.Буманбаяр /АЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга/
- Б.Эрдэнэбаатар /АЗДТГ-ын НБХ-ийн дарга/
- О.Ундрах /АЗДТГ-ын ХМОНХА-ны дарга/
- Ч.Амгалан /Хүнс, Хөдөө, Аж Ахуйн Газрын дарга/
- Э.Түвшинмөнх /Боловсрол, соёлын газрын дарга/
- Н.Батжаргал /Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга/
- С.Нарантуяа /Эрүүл, мэндийн газрын дарга/
- Ц.Энх-Амгалан /Нийгмийн даатгалын хэлтсийн дарга/
- Т.Баярбат /Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга/
Нарийн бичгийн дарга: - М.Батчимэг /АЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн/

2. “Хүний хөгжлийн дэмжих жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг иргэн, төр, хувийн хэвшлийн байгууллагуудын саналыг тусган боловсруулж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн дотор хэлэлцүүлэн батлуулахыг Ажлын хэсэг /Ц.Бат-Өлзий/-т даалгасугай.



З.БАТЗОРИГ

Аймгийн Засаг дарга 2019 он А-4

20200033